



БОДЬ ДААТГАЛ
ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮЧ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 24/01

Улаанбаатар хот

КОМПАНИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсгийг удирдлага болгон Бодь даатгал ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2024 оны 04 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Бодь даатгал ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1-т заасны дагуу баталсугай.

ХУРЛЫН ДАРГА  А.ЭНХЖАРГАЛ



САНХҮҮГИЙН ТАЙЛАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

Бодь Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

2023 онд Монгол улсын эдийн засгийн бодит өсөлт 7.0 хувь, инфляцын түвшин 7.9 хувь гарсан бол даатгалын салбарын цэвэр хураамж 26.0 хувиар өссөн байна. Цэвэр хураамжийн өсөлтөд тээврийн хэрэгслийн даатгалын хураамж болон хөрөнгийн даатгалын хэлбэрт цэвэр хураамж өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

“Бодь Даатгал” ХК-ийн хувьд 2023 онд бүтээгдэхүүний багцын эрсдэлийг бууруулахад гол зорилго тавин ажилласан бөгөөд үүнтэй холбоотойгоор андеррайтингийн хатуу бодлогыг хэрэгжүүлж, улмаар үр дүнд цэвэр хураамжийн орлого 6.7 хувиар буурч 22.1 тэрбум төгрөгт хүрсэн. Хэдийгээр цэвэр хураамжийн хэмжээ буурсан боловч хохирлын харьцаа үзүүлэлт 60.9 хувиас 48.1 хувьд хүрч 12.8 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй гарсан.

Цэвэр хураамжийн орлогын 74 хувийг Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал, Тээврийн хэрэгслийн даатгал болон Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал бүрдүүлж байна.

Харин орлогын тайлангийн гол үзүүлэлт болох орлогод тооцсон хураамжийн хэмжээ 24.6 тэрбум төгрөгт хүрсэн ба өмнөх оноос даруй 23.5 хувиар өссөн байна. Үүнд 2022 онд хийгдсэн Оюу толгой ХХК-ийн Эрүүл мэндийн даатгалын гэрээг үргэлжлүүлэн 6 сараар нөхцлийг сайжруулан сунгасан нь хүчтэй нөлөөг үзүүлсэн байна. Цэвэр нөхөн төлбөрийн зардал 2.5 хувиар буюу 303.1 сая төгрөгөөр буурсан нь ашигт ажиллагаанд тус хэмжээгээр эерэг нөлөөг үзүүлжээ. Мөн үйл ажиллагааны зардлыг бууруулах хэд хэдэн үе шаттай арга хэмжээний хүрээнд зардлын харьцаа үзүүлэлт 58.9 хувиас 47.7 хувь хүртэл 11.2 хувиар буурч улмаар төлөвлөсөн ашигт ажиллагааны гүйцэтгэл 67 хувьтай хангагдлаа.

Төлбөрийн чадварын үзүүлэлт:

Давхар даатгалын хойшлогдсон хураамж болон нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийг хассан даатгагчийн цэвэр хөрөнгийн хэмжээ 28.4 тэрбум төгрөг байна. Нийт цэвэршүүлсэн хөрөнгийн 13.0 хувь буюу 3.8 тэрбум төгрөгийг зөвшөөрөгдөхгүй хөрөнгө эзэлж байна. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт нь Санхүүгийн зохицуулах хорооноос шинээр батлан хэрэгжүүлж буй “Эрсдэлд суурилсан хөрөнгийн үнэлгээний аргачлал”-аар тайлант оны 02 дугаар улиралд 4-р түвшинд байсан бол жилийн эцсээр 2-р түвшинд очсон байна. Үүнд төлбөрийн чадварыг сайжруулах төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд буюу авлагын бууралт, хөрөнгө оруулалт буюу банкин дахь хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлсэн зэрэг нь багагүй эерэг нөлөөллийг бий болгожээ.

Нөөцийн сан:

2023 оны байдлаар нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээ 6.47 тэрбум төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 54.6 хувиар буюу 2.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнээс 11.0% буюу 714.7 сая төгрөгийг давхар даатгагчид ногдох нөөц сан бүрдүүлж байна.

Нөөц сангийн өсөлтөд мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн өсөлт голлох нөлөө үзүүлсэн нь нийт нөхөн төлбөрийн хэмжээ өмнөх оноос 0.2 хувиар буюу 24.4 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Компанийн цэвэр хосолсон харьцаа 95.8% гарсан ба үүнтэй холбоотойгоор 1.5 тэрбум төгрөгийн учирч болзошгүй хохирлын нөөц сан байгуулсан. Тус нөөц сан өндөр байгуулагдсан нь хөрөнгийн даатгал, барилга угсралтын даатгал болон жолоочийн хариуцлагын даатгалын хувьд хосолсон харьцаа өндөр гарсан байгаа нь тус тус нөлөөлжээ.

Компанийн 2023 оны санхүүгийн үр дүнгээс харахад гүйцэтгэх удирдлагын багийг сайн ажилласан гэж үзлээ.

Цаашид даатгалын андррейтингийн үйл ажиллагааны хяналтыг илүү сайжруулж, байгаль цаг уурын өөрчлөлттэй холбоотой эрсдэлд суурилсан хураамжийн өөрчлөлтийг санал болгох замаар даатгалын хэлбэрийг төрөлжүүлж, хосолсон харьцааг бууруулж ашигт ажиллагааг өсгөхөд анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ